



Н.Гэндэнжамцын нэрэмжит
ЭХ ХҮҮХДИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ

Н.ГЭНДЭНЖАМЦЫН НЭРЭМЖИТ
• ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ

16060 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
Хувьсгалчдын гудамж, ЭХЭМҮТ
Утас: 362205, Факс: 976-11-362633
И-мэйл: ehemut@ncmch.gov.mn
Веб: www.ehemut.mn

САММИТМЕДИКАЛ
СЕРВИС ХХК-д

2024. 03. 25 № 187

танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

Тус төв нь улсын хэмжээнд эх, хүүхдийн төрөлжсөн тусламж үйлчилгээг үзүүлдэг бөгөөд шинэ технологийн мэс засал, эмийн эмчилгээ хийж байгаатай холбоотой 2024 онд MRI шинжилгээнд шаардагдах (Гадотерын хүчил, Гадексетын хүчил, олон улсын нэрээр) тодосгогч бодис худалдан авах ЭХЭМҮТ/20240102009/01/01 дугаартай тендер зарласан. Гадотерын хүчил нь Artirem, Dotarem, Clariscan г.м (https://en.wikipedia.org/wiki/Gadoteric_acid#cite_note-1) олон төрлийн худалдааны нэртэй бөгөөд бид тендерийн баримт бичигт эдгээр нэрсийг дурдаагүй болно. Иймээс хуулийн 12.4 заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.

Түүнчлэн гадотерын хүчил нь (www.drugsinfo.mohs.mn) нярай болон хөхүүл насны хүүхдэд болгоомжтой, бусад насны хүүхдэд хэрэглэх ба гаж нөлөө ховор илрэх заавартай байгааг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын вэб хуудаснаас (www.druginfo.mohs.mn) харж болно.

Тус төв MRI шинжилгээ хийж эхлэх үед Гадовист тодосгогчийн үйлдвэрлэгчийн зааврын дагуу өсвөр насны хүүхдэд хэрэглэхээр арьсан дотор сорил тавихад 15 хүүхдэд харшлын урвал өгсөн тул бид зөвхөн эмэгтэйчүүдийн эмгэгтэй хүнд цөөн тоогоор хэрэглэж байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын вэб хуудсанд Гадобутерол нь зөвхөн насанд хүрэгчдэд хэрэглэх, хөхүүл, жирэмсэн эхэд хэрэглэхгүй заавартай байгаа тул 2024 онд худалдан авалт хийхгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Ш.АЛТАНТУЯА